

Түүх 9 : Даниел

Библийн эшлэл
[Даниел 6:27]

Тэрээр тэнгэр, газарт аварч, чөлөөлж, Гайхамшиг, тэмдгүүдийг үйлддэг.
Тэрээр бас Даниелыг арслангийн савраас аварсан» хэмээв.



Небухаднезар хаан нас бараад, Дариус хаан Вавилоныг захирч байх үед болсон явдал ажээ.

Дариус хаан боолчлогдон ирсэн хүмүүс дундаас мэргэн ухаантай, зан чанар сайтай Даниелыг сонгон сайд болгожээ.

Гэтэл бусад сайд түшмэлүүд Даниелд дургүй байлаа. Тэд Даниелын сул талыг олж хорлох гэж оролдовч түүнд сул тал байхгүй байлаа. Тиймээс сайд түшмэлүүд хаан дээр очоод нэгэн саналыг дэвшүүлэв.

“Хаантан минь, энэ улсад танаас өөр хэн нэгэнд мөргөж үйлчилсэн хүн байна.”

“Цаашид гучин өдрийн турш зөвхөн хаан танд л мөргөж үйлчилнэ гэсэн хуулийг баталж өгнө үү.

Хаан таниас өөр ямар нэгэн бүрхдад мөргөж үйлчилсэн хүн байвал тэр хүнийг арслангийн агуйд шидэх шийтгэл өгье”

Дариус хаан шинэ хуулийг зөвшөөрч тамгаа даржээ. Тэгээд хааны элч нар шинэ хуулийг бүх ард түмэнд зарлав.

Даниел энэ хуулийг сонссон ч гэсэн өдөр бүр гурван удаа Бурханд өвдөг сөгдөн залбирч, Бурханд тасралтгүйгээр талархсаар байв. Гэтэл нэгэн түшмэл хаанд ингэж хэлэв.

“Хаантан минь, би хэлээгүй юу!.... Улсын хуулийг зөрчиж Бурханд хандан залбирч мөргөсөн Даниелийг арслангийн агуй руу шидэх хэрэгтэй шүү дээ...” Хаан Даниелд маш сайн ханддаг байсан боловч хуулийг зөрчсөн учир яаж ч чадалгүй арслангийн агуй руу хийхийг зөвшөөрөв. Тэгээд Хаан Даниелд ингэж хэлэв. “Чиний хүндэлж мөргөдөг Бурхан чамайг аврах болтугай.”

Даниел арслангийн нүхнээс Бурхан уруу хандан залбирч байлаа.

Харин хаан Даниелд санаа зовон хоол ч идэж чадахгүй, шөнө нь унтаж ч чадахгүй байв.

Өглөө болмогц хаан эртлэн босож, өлсгөлөн арслангийн нүх рүү явав.

Гэтэл арслангийн нүхэнд Даниел маш тайван харагдаж байлаа. Өлсгөлөн арслангууд Даниелийн хажууд байгаа харагдана.


Үүнийг харсан хаан маш ихээр баярлажээ.

Тэгээд Даниелыг гүтгэсэн хүмүүсийг олж илрүүлээд, хаан ихэд уурлан тэднийг гэр бүлийнхэнтэй нь хамт арслангийн нүхэнд шидчихжээ.

Ийнхүү хаан ард түмэндээ хандан Даниелын итгэдэг Бурханыг магтан хүндлэх тушаалыг буулгажээ.

Харин Даниел насан туршдаа Бурханд итгэн, Түүнд итгэмжтэй байж, амар тайван амьдарчээ.





- Дараах эшлэлийг дагаж бицээд, цээжлээрэй. (Даниел 6:27)

... Даниелыг аварсан ...

Үйл ажиллагаа 2.

Бүх зургийг хайчилж жишээ зурагтай адилхан болгоорой. Үүний дараа арслангийн аманд маскийг байршуулаарай. Даниелийг хамгаалсан Бурханыг бодож үзээрэй.

